



УЛААНБААТАР ХОТЫН ШУУРХАЙ УДИРДЛАГА,  
ЗОХИЦУУЛАЛТЫН ТӨВ ОНӨААТҮГ  
ДАРГЫН ТУШААЛ

2017 оны 12 сарын 04 өдөр

Дугаар А/24.

Улаанбаатар хот

Тооллогын комисс байгуулах тухай

Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 72.1, Нийслэлийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын Тэргүүлэгчдийн 2013 оны 145 дугаар тогтоолоор батлагдсан “Улаанбаатар хотын Шуурхай удирдлага, зохицуулалтын төв” орон нутгийн өмчит аж ахуйн тооцоот үйлдвэрийн газрын дүрмийн 4 дүгээр хэсгийн 4.9.9, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 70 дугаар зүйлийн 2.2, Хөдөлмөрийн дотоод журмын 8.2.3 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын үндсэн хөрөнгө болон хангамжийн материалын тооллогын ажлыг зохион байгуулах ажлын хэсгийг дараах бүрэлдэхүүнтэй байгуулсугай.

Комиссын ахлагч:	Н.Батсүх	Дотоод хяналт, хамтын ажиллагаа хариуцсан ахлах мэргэжилтэн
Гишүүд:	Д.Бауыржан	Ахлах диспетчер инженер
	П.Батбилэг	Системийн ахлах инженер
	Г.Билгүүн	Техник хангамжийн инженер
Нарийн бичгийн дарга:	С.Алтандэлгэр	Диспетчер инженер

2. Тооллогыг 2017 оны 12 дугаар сарын 04-07-ны өдрүүдэд зохион байгуулж, дүн мэдээг 2017 оны 12 дугаар сарын 08-ны дотор Өмч хамгаалах байнгын зөвлөлд танилцуулахыг Тооллогын комисс /Н.Батсүх/-т үүрэг болгосугай.

ДАРГА



Ч.ГАН-ОЧИР